

Загасчин байсан дагалдагчид

-Fishers of Men-



22Page


- Тайлбарлагч** Нэгэн өдөр Есүс Галил нуур уруу явав. Галил нуурт Петр, Андрей хэмээх ах дүү хоёр завинд дээрээс загасчилж байлаа.
- Петр** Шөнөжингөө загасчиллаа. Нэг ч загас барьсангүй шүү.....ёстой нээрээ
- Тайлбарлагч** Загас барьж чадаагүйд сэтгэлээр унасан Петр, Андрей хоёр тороо угааж байлаа.



23Page

- Тайлбарлагч** Яг энэ үед, Есүс тэр газарт очдог. Олон хүмүүс Есүсийг даган ирсэн байлаа. Есүс Петрийн завинд суугаад сургаалиа зааж эхлэв.
- Есүс** Завиа эргээс холдуулж өгч болохуу?
- Тайлбарлагч** Петр тэр даруй эргээс завийг холдуулав. Тэнд байсан бүх хүмүүс Есүсийн царайг сайн харж чадахаар байв. Есүс хүмүүст, тэнгэрийн хаанчлалын тухай баярт мэдээг хичээнгүйлэн заав. Хэсэг хугацааны дараа Есүс, Петрт хандан ингэж хэлэв.
- Есүс** Усны гүн рүү тороо шидээд үз
- Петр** Багшаа бид шөнөжингөө загасчлаад юу ч барьж чадсангүй. Гэсэн ч таны үгийн дагуу хийе

- Тайлбарлагч** Петр, Андрей хоёр багаасаа загас барьж сурсан, хэнээс ч илүү загас барихыг сайн мэддэг байв. Гэтэл шөнөжингөө баригдаагүй загас дахин баригдахгүй гэдгийг мэдэж байсан ч зөрүүдлэлгүй, тэр даруй Есүсийн үгийн дагуу хийлээ.



24Page

- Петр** Хөөх, Юу болох нь энэ вэ? гайхалтай,, бөөн загас...
- Тайлбарлагч** Петр, Андрей хоёр үнэхээр их гайхаж хоцров. Тэр газраас холгүйхэн Иаков, Иохан хэмээх ах дүү хоёрын завь бас байв. Иаков, Иохан хоёр энэ гайхалтай зүйлийг харан, сандран, айж Есүсийн хөлд сөхрөн суув. Есүс тэдэнд:
- Есүс** Бүү айгтун. Үүнээс хойш чи хүмүүсийг загасчлах болно!
- Тайлбарлагч** Үүнийг сонсоод тэд бүгд завиа орхин Есүсийг даган явцгаав. Ингэж Петр болон Андрей, Иаков, Иохан нар Есүсийг дагадаг дагалдагчид болсон гэдэг.



25Page

Тайлбарлагч

Нэгэн өдөр Есүс Матай гэдэг хүнтэй уулзав. Матай татвар хураагч хүн байв. Тэр үед татвар хураагчид татварыг тогтоосон хэмжээнээс их хураадаг байсан тул хүмүүст үзэн ядагддаг байлаа. Шуналтай, гэмтэй нэгэн хэмээн ад үзэгддэг Матайтай уулзаад, Есүс түүнд ингэж хэлэв.

Есүс

Намайг дага



26Page

Тайлбарлагч

Матай энэ үгийг сонсонгуутаа хийж байсан бүхнээ орхиод Есүсийг даган түүний дагалдагч болов. Есүс, Матайгийн гэрт уригдан олон татвар хураагчидтай хооллож байхыг харсан фарисайчууд хоорондоо шивнэлдэж эхлэв.

Фарисай

Хүүе, нөгөө Есүс чинь гэмтэнгүүдтэй хамт хооллож байх чинь?

Есүс

Эмч эрүүл хүнд бус өвчтэй хүнд хэрэгтэй байдаг шиг би зөвт хүмүүсийн төлөө бус харин гэмт хүмүүсийн төлөө ирсэн. Тиймээс энэ хүмүүстэй хамт байгаа юм



27Page

Тайлбарлагч

Ингэж Есүс 12 дагалдагчаа дуудсан юм. Тэд Есүстэй 3 жилийн турш хамт байж, багш болох Түүнээс олон зүйлийг сурч мэдэж авсан.

Дагалдагч нар нь хожим Түүнийг дээш өргөгдсөний дараа Есүсийн хийж байсан ажилуудыг яг адилханаар хийцгээсэн юм.